Төв аймгийн Баянхангай сумын Засаг дарга нь төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх нөхцөлийг хангаж, төрийн захиргааны мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн ажил үйлчилгээг иргэдэд ил тод хөнгөн шуурхай хүргэх таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Тус байгууллага мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Баянхангай сумын Засаг дарга нь 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/21 тоот захирамжаар дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан ба 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/35 тоот сумын Засаг даргын захирамжаар сумын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг шинэчлэн батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна.

Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна.

Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт орлогоос 1,5 хувиар буюу 35,923.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80,0 хувиар буюу 28,738.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт орлого 3,479,584.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 52,193.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 16,270.4 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 41,754.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянхангай сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эм эргэлтийн сан зэрэг 10 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 683,569.0 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 1,136,646.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 6,064.7 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 26,241.0 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 94,522.0 мянган төгрөг, Эм, эргэлтийн сангийн орлого 72,839.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 228,159.1 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 111,593.6 мянган төгрөг, нийт 2,359,636.5 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний тайлангаар төвлөрүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлогыг хоорондын тооцоогоор устгал хийсэн байна.

Баянхангай сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 06 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 47,562.2 мянган төгрөг, татварын бус орлогыг 46,800.0 мянган төгрөг, нийт 94,362.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 56,215.3 мянган төгрөг, татварын бус 17,231.4 мянган төгрөг буюу 118,3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 37,458.2 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 987,846.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, 26,222.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, нийт 1,054,237.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 17,399.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 300,755.7 мянган төгрөгийн, хандив, бусад эх үүсвэрээр 129,681.0 мянган төгрөгийн, нийт 430,436.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 370,914.9 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ажиллагчидтай холбогдсон авлага 150.0 мянган төгрөг, байгууллагаас авах 82,259.7 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 251,984.9 мянган төгрөг, нийт 334,394.6 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Үүнд:

ЗДТГ нь 150.0 мянган төгрөгийн цалингийн авлага үүссэнийг барагдуулаагүй, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 251,984.9 мянган төгрөг, эм эргэлтийн сангийн авлага 4,183.2 мянган төгрөг, ЭМТ-ийн авлага 78,076.5 мянган төгрөг байна.

Өглөгийн үлдэгдлээр ажилчидтай холбогдсон өглөг 1,506.1 мянган төгрөг, байгууллага, хувь хүмүүсийн 375.1 мянган төгрөг, нийт 1,881.1 мянган төгрөг нэгтгэгдсэн байна. Үүнд: ОНХС 250.6 мянган төгрөг, ЗДТГ 1,506.0 мянган төгрөг, СХС 95.5 мянган төгрөг, ЭЭС 29.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 83,346.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 4,615.2 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 6,544.5 мянган төгрөг, нийт 94,506.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 60,127.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 6,324.1 мянган төгрөг байршиж байна.

Бараа материал 216,203.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3077,249.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	73,258.3	94,506.2	21,247.9
Авлага	250,739.0	334,394.6	83,655.6
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	156,682.2	216,203.9	59,521.7
Үндсэн хөрөнгө	2,196,365.9	3,077,249.1	880,883.2
Нийт хөрөнгө	2,677,045.4	3,722,353.8	1,045,308.4
Өр төлбөр	1,713.5	1,881.1	167.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,675,331.9	3,720,472.7	1,045,140.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,677,045.4	3,722,353.8	1,045,308.4

Бараа материалын дансны үлдэгдэл 216,203.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 59,521.7 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материалын үлдэгдэл 42,397.3 мянган төгрөг, аж ахуйн ахуйн материалын үлдэгдэл 11,912.8 мянган төгрөг, хүнсний материал 8,446.1 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1,582.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,077,249.1 мянган төгрөг болж 880,883.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 1,054,237.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Тайлант онд ЗДТГ-т орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 51,253.5 мянган төгрөг, СӨБ тоног төхөөрөмж 560.0 мянган төгрөг, ЕБС-ийн Дотуур байрны барилга 914,579.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж 21,454.1 мянган төгрөг, нийт 936,033.4 мянган төгрөг, ЭМТ нь 25,914.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,720,472.7 мянган төгрөг болж 1,045,140.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд хүргүүлсэн саналыг шилэн дансны цахим хуудсанд байршуулж, мэдээлээгүй, аудитын явцад төсвийн төслийн талаарх мэдээлэл ирүүлээгүй болно.

Баянхангай сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 06 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 47,562.2 мянган төгрөг, татварын бус орлогыг 46,800.0 мянган төгрөг, тайлант оны орлогыг нийт 94,362.2 мянган төгрөгөөр, 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,997,981.0 мянган төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 51,134.6 мянган төгрөгөөр тус тус баталсан.

Сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2,029,468.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,932,670.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 75,793.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 51,134.6 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,059,598.5 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнөөс 21,004.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Тайлант оны зардлын 1,154,836.3 мянган төгрөгийг Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, 1,898,052.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилт, 20,848.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, 90,865.5 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангийн санхүүжилт, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 100,000.0 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,842,640.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 67,181.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 98,320.5 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 34,746.6 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 24,626.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,008,142.9 мянган төгрөг буюу 97,5 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 230,659.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 167,749.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 55,450.5 мянган төгрөгийн зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 2,843.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 4,615.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баянхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС-гийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгч, 48,652.4 мянган төгрөгийн залруулга хийлгэж, 6,901.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 376,911.4 мянган төгрөгийн албан шаардлага, 44,106.3 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дундманхайдай Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сан гэсэн 4 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн ба ЕБС-ийн санхүүгийн тайланд 76,399.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 5,777.4 мянган төгрөгийн залруулга хийлгэж, 27,795.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 241.8 мянган төгрөгийн залруулга хийлгэж, 1,058.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 47,868.9 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Баянхангай сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2,029,468.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,080,602.6 мянган төгрөгийн батлагдсан төлөвлөгөөг 2,059,598.5 мянган төгрөг буюу 21,004.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь сумын ИТХ-аас төсөв батлахдаа Эрүүл мэндийн төвийн орон нутгаас санхүүжих 20,907.4 мянган төгрөгийг давхардуулан, СӨБ-ийн тусгай зориулалтын шилжүүлгийг 96.4 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад ИТХ цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварт 2,904.1 мянган төгрөгийг төлсөн байхад татварын тооцооллын үлдэгдэл 1,174.9 мянган төгрөгийн дутуу төлөлттэй, хувь хүнд олгосон суутгаж, төлсөн албан татвар 190.2 мянган төгрөг байхад татварын тооцооллоор 69.3 мянган төгрөгийн илүү төлөлт, ЕБС 2,031.8 мянган төгрөгийн дутуу, 95.6 мянган төгрөгийн илүү төлөлт, Цэцэрлэг 344.5 мянган төгрөгийн дутуу, ЗДТГ цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварт 5,184.5 мянган төгрөгийн илүү зөрүүтэй байна. Татварын байцаагч нь Орон нутгийн татварын орлогуудын тооцооллыг хийдэггүйгээс татварын албаны тодорхойлолтоор илүү, дутуу үлдэгдэлтэй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 6, огт байршуулаагүй 5 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/246 дугаар албан бичгээр ирүүлсэн. Өмнөх аудитаар өгөгдсөн

ИТХ-аар төсөв батлахдаа тоон мэдээллийг үнэн зөв батлах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв гүйцэд байршуулах гэсэн зөвлөмж давтагдаж байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын дагуу сумын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 219,471.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,418.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,078.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 64,687.8 мянган төгрөгийн албан шаардлага, 148,287.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

ИТХ нь санхүүгийн үр дүнгийн тайланд өмнөх оны үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнаснаас нийт үр дүнг 3,138.1 мянган төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлого 280.0 мянган төгрөгийг орхигдуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Баянхангай сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нь 2021 оны 5 дугаар сард 1 сарын үндсэн цалингийн 20 хувиар сахилгын арга хэмжээ тооцогдсон байхад сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 37 дугаар тогтоолоор үр дүнгийн 40 хувийн урамшуулалд 316.9 мянган төгрөг, малын шүлхий өвчний үед жижүүр постод ажилласан нэмэгдэл хөлсийг 568.7 мянган төгрөгөөр илүү олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Аудитын явцад орон сууц түрээслэгчдийн 2021 оны тооцоог өрх бүрээр хийлгэхэд түрээсийн орлогоор 4,372.5 мянган төгрөг төвлөрөхөөс 2,192.5 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр биелүүлсэн эсэхийг шалгахад Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 5,988.2 мянган төгрөгөөр буюу 42,8 хувиар, Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 2,212.2 мянган төгрөг буюу 22,1 хувиар, газрын төлбөр 5,686.7 мянган төгрөг буюу 63,4 хувиар, бууны албан татвар 30.0 мянган төгрөгөөр буюу 5,3 хувиар нийт 4 нэр төрлийн орлого 13,917.1 мянган төгрөгөөр тасарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 50,770.7 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын мэдээтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөв батлахдаа Эрүүл мэндийн төвийн орон нутгаас санхүүжих 20,907.4 мянган төгрөгийг давхардуулан, СӨБ-ийн тусгай зориулалтын шилжүүлгийг 96.4 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан ба улсын тэмдэгтийн хураамжийн дансанд 500.0 мянган төгрөгийн тамхины зөвшөөрлийн төлбөр, 168.0 мянган төгрөгийн хогийн хураамж төвлөрүүлсэн, үйл ажиллагааны орлогын албан татварын дансанд 192.9 мянган төгрөгийн газрын төлбөр зэргийг буруу төвлөрүүлж, мэдээлсэн, аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр 94,2 мянган төгрөгөөр буюу нийт 6 нэр төрлийн орлогын дүн зөрүүтэй мэдээлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын ангилал, тоон мэдээллийг үнэн зөв баталгаажуулж, орлогын мэдээ тайланг санхүүгийн үндсэн баримтад тулгуурлан нэр төрлөөр болон үнийн дүнг зөв ангилан мэдээлж хэвших

2. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 55,634.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

3. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эмийн эргэлтийн санд хийсэн аудитаар тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 144 мэдээллээс 37 мэдээллийг хугацаа хоцроож, 25 мэдээллийг мэдээлээгүй, Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 10 нэр төрлийн 4,291.4 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө, 4 нэр төрлийн 1,385.0 мянган төгрөгийн үнэ бүхий биет бус хөрөнгө бүртгэлтэй, 400.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын орлого авалгүй өглөгийн данснаас шууд зардалд бүртгэсэн, 64,617.4 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй зэрэг нийт 70,693.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд...”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эмийн эргэлтийн сангийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, шилэн дансны мэдээллийг сайжруулах ба худалдан авалтын цахим баримтыг тухай бүрд авч хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Засаг дарга	8	219,471.6	1	3,418.1	2	3,078.1	2	64,687.8	3	148,287.6
2	ЗДТГ	10	476,571.9	3	48,652.4	4	6,901.8	1	376,911.4	2	44,106.3
3	ЕБС	3	76,399.6							3	76,399.6
4	ЭМТ	5	49,169.0	1	241.8	1	1,058.3			3	47,868.9
5	СӨБ	4	33,572.6	1	5,777.1					3	27,795.5
6	Нийт дүн	30	855,184.7	6	58,089.4	7	11,038.2	3	441,599.2	14	344,457.9

